

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	14
3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	14
3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ .....	14
3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ .....	17
3.4. Материаллаг байдал .....	17
3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	17
3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ .....	19
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	20
3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	20
3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
Залруулсан алдаа.....	21
Аудитын зөвлөмж.....	22
3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД.....	22
4. Менежментийн захидал .....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	26



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ  
ЭМНЭЛГИЙН ДАРГА Н.ЛХАЖИЙ  
ТАНАА

2021.02.25 № 07/559  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын санал дүгнэлт

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь тайлант онд 4 зорилтот бүлгийн хүрээнд 70 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88,45 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.  
**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 710,983.2 төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс 288,688.4 мянган төгрөгөөр давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн, зөв шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,323,561,943.66</b>	<b>5,800,825,005.78</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	34,290,120.00	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	34,290,120.00	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	34,290,120.00	-
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	34,290,120.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>95,939,933.60</b>	<b>67,326,928.41</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	748,499.00	175,202.77
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		3,576,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	94,827,209.00	60,255,074.33
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>364,225.60</b>	<b>3,320,651.31</b>
3351	Байгууллагаас авах авлага	364,225.60	3,320,651.31
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,193,331,890.06</b>	<b>5,733,498,077.37</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,432,448,333.59</b>	<b>1,799,020,521.71</b>
35110	Тусгай зориулалттай материал	70,710,319.80	237,038,242.67
35130	Эм боох материал	1,361,738,013.79	1,561,982,279.04
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,719,214,692.00	3,873,384,258.85
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>41,668,864.47</b>	<b>61,093,296.81</b>
35410	Бичиг хэргийн материал	5,379,165.00	7,132,517.84
35420	Аж ахуйн материал	1,314,267.00	2,696,873.00
35430	Сэлбэг хэрэгсэл	24,839,086.19	49,520,913.99
35440	Түлш, шатах тослох материал	5,011,997.07	1,642,266.41
35450	Барилгын засварын материал	5,124,349.21	100,725.57
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,352,898,315.06</b>	<b>44,096,899,839.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>39,352,898,315.06</b>	<b>44,096,899,839.02</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>38,488,644,672.92</b>	<b>43,210,474,317.80</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	23,257,685,466.49	25,297,563,870.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(434,702,286.72)	852,326,251.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	204,386,416.00	204,386,416.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(170,243,632.22)	181,750,097.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,194,824,741.34	49,508,145,860.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,320,099,850.18)	31,444,073,317.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	989,182,718.29	1,033,592,876.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(421,987,715.36)	462,365,166.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	284,216,791.71	284,216,791.71
39215	Хуримтлагдсан элэгдэл	(158,433,139.93)	176,916,663.92)
39217	Ном	63,815,163.50	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>864,253,642.14</b>	<b>886,425,521.22</b>
39301	Програм хангамж	89,191,903.00	124,191,903.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(55,323,360.86)	68,151,481.78)
39303	Бусад биет бус хөрөнгө	830,385,100.00	830,385,100.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>44,676,460,258.72</b>	<b>49,897,724,844.80</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53,406,807.75</b>	<b>653,218,852.29</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>53,406,807.75</b>	<b>653,218,852.29</b>
<b>412</b>	<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>38,421,874.75</b>	<b>35,348,115.45</b>
<b>4121</b>	<b>Төгрөг</b>	<b>38,421,874.75</b>	<b>35,348,115.45</b>

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	38,421,874.75	35,348,115.45
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>14,984,933.00</b>	<b>617,870,736.84</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	43,343.00	
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		34,165,577.60
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>14,941,590.00</b>	<b>583,705,159.24</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	14,591,590.00	583,705,159.24
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	350,000.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>44,623,053,450.97</b>	<b>49,244,505,992.51</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>44,623,053,450.97</b>	<b>49,244,505,992.51</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,376,629,291.33	21,376,629,291.33
51101	Өмч: - төрийн	21,376,629,291.33	21,376,629,291.33
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>13,831,830,226.50</b>	<b>18,453,282,768.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	13,438,933,990.62	13,831,830,226.50
51220	Тайлант үеийн үр дүн	392,896,235.88	4,621,452,541.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,414,593,933.14	9,414,593,933.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>44,676,460,258.72</b>	<b>49,897,724,844.80</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/Төгрөгөөр/ Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>42,636,683,259.22</b>	<b>53,820,712,811.15</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,192,628,941.22</b>	<b>15,324,454,221.15</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,960,904,402.70</b>	<b>15,295,954,221.15</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,960,904,402.70	15,295,954,221.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,677,828,291.00	5,927,628,579.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	283,076,111.70	1,602,673,784.35
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		7,765,651,857.80
122	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,231,724,538.52</b>	<b>28,500,000.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	3,231,724,538.52	28,500,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>34,444,054,318.00</b>	<b>38,496,258,590.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	12,515,218,600.00	14,507,014,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,515,218,600.00	14,507,014,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,136,115,327.00</b>	<b>4,066,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,253,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	284,008,200.00	4,066,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	829,854,127.00	
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,792,720,391.00</b>	<b>23,985,178,390.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,792,720,391.00	23,985,178,390.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>42,230,520,362.86</b>	<b>49,199,260,269.61</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>42,230,520,362.86</b>	<b>49,199,663,056.95</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>41,395,481,883.33</b>	<b>48,787,385,122.95</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,409,567,827.40</b>	<b>12,919,211,314.07</b>
210101	Үндсэн цалин	5,579,374,962.40	6,505,727,715.07
210102	Нэмэгдэл	3,001,226,834.00	4,767,724,682.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	869,900,000.00	884,855,625.00
210104	Урамшуулал	638,613,007.00	760,903,292.00
210105	Гэрээт ажлын хөлс	320,453,024.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,324,716,901.96</b>	<b>1,652,568,693.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	903,789,482.80	1,137,101,182.97
210202	Тэтгэмжийн даатгал	111,947,910.77	140,529,178.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	82,558,087.85	102,007,138.02
210204	Ажилгүйдлийн даатгал	19,928,265.18	25,191,388.78
210205	Эрүүл мэндийн даатгал	206,493,155.36	247,739,804.84
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>821,564,201.11</b>	<b>933,246,606.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	417,307,074.43	539,802,836.36
210302	Түлш, халаалт	206,606,156.82	175,301,684.80
210303	Цэвэр, бохир ус	197,650,969.86	218,142,085.47



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>484,564,366.93</b>	<b>998,132,019.89</b>
210401	Бичиг хэрэг	114,933,478.22	188,268,072.16
210402	Тээвэр, шатахуун	28,801,802.81	40,997,770.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,081,577.79	22,021,862.96
210404	Ном, хэвлэл	1,241,727.00	5,151,753.45
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	310,764,001.11	738,624,211.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,741,780.00	3,068,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,847,008,051.44</b>	<b>25,567,242,204.47</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,066,177,551.44	24,970,930,204.47
210502	Хоол, хүнс	779,950,500.00	596,312,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	880,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>934,158,519.93</b>	<b>618,075,374.16</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,075,820.00	9,100.00
210604	Урсгал засвар	855,082,699.93	618,066,274.16
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>93,111,400.00</b>	<b>7,839,100.00</b>
210701	Гадаад албан томилолт	87,594,200.00	
210702	Дотоод албан томилолт	5,517,200.00	7,839,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>250,398,027.33</b>	<b>303,633,750.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	234,344,495.00	286,688,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,900,000.00	9,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	317,612.00	1,167,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	463,328.33	492,260.00
210807	Газрын төлбөр	5,372,592.00	5,385,450.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,230,392,587.23</b>	<b>5,787,436,060.19</b>
<b>210901</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>190,420,727.18</b>	<b>497,063,121.20</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,706,526.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,970,265,334.05	5,290,372,938.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>835,038,479.53</b>	<b>412,277,934.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>759,006,038.00</b>	<b>408,211,934.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	260,994,692.00	252,516,054.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	362,588,062.00	153,267,880.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	135,423,284.00	2,428,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>76,032,441.53</b>	<b>4,066,000.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,032,441.53	4,066,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>(402,787.34)</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>(402,787.34)</b>
223001	Бусад хөрөнгө		(402,787.34)
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>406,162,896.36</b>	<b>4,621,452,541.54</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>(13,266,660.48)</b>	<b>-</b>
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	(13,266,660.48)	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(13,266,660.48)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>392,896,235.88</b>	<b>4,621,452,541.54</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>39,484,714,002.16</b>	<b>46,267,290,002.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,964,029,606.20</b>	<b>7,734,758,602.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,964,029,606.20</b>	<b>7,734,758,602.05</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,964,029,606.20</b>	<b>7,734,758,602.05</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,678,334,396	5,904,779,273.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	285,695,210	1,829,979,328.14
122	Тусламжийн орлого		28,500,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		28,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>34,520,684,395.96</b>	<b>38,504,031,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>12,515,218,600.00</b>	<b>14,507,014,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,515,218,600.00	14,507,014,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,212,745,404.96</b>	<b>4,066,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,253,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн ТЗ-д хуваарилсан хөрөнгө	284,008,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны ТЗ-д хуваарилсан хөрөнгө	906,484,204.96	4,066,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,792,720,391.00</b>	<b>23,992,951,200.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,792,720,391.00	23,992,951,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>37,516,152,544.16</b>	<b>43,623,804,476.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,516,152,544.16</b>	<b>43,623,804,476.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>36,586,316,855.63</b>	<b>43,153,548,567.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>10,433,873,327.82</b>	<b>12,695,290,300.00</b>
210101	Үндсэн цалин	5,966,405,754	7,410,082,100
210102	Нэмэгдэл	3,015,951,207	3,811,188,200
210103	Унаа хоолны хөнгөлөлт	866,080,367	866,250,000
210104	Урамшуулал	585,436,000	607,770,000
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,303,239,341.00</b>	<b>1,669,205,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	890,354,741	1,242,689,200
210202	Тэтгэмжийн даатгал	103,221,200	106,629,100
210203	ҮОМШӨ-ний даатгал	82,576,900	85,303,200
210204	Ажилгүйдлийн даатгал	20,644,200	21,325,800
210205	Эрүүл мэндийн даатгал	206,442,300	213,258,100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>824,197,355.30</b>	<b>937,786,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	374,519,614	536,986,633
210302	Түлш, халаалт	209,239,311	185,717,204
210303	Цэвэр, бохир ус	240,438,430	215,082,963
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>288,760,746.79</b>	<b>316,704,491.96</b>
210401	Бичиг хэрэг	34,492,295	51,846,545
210402	Тээвэр, шатахуун	26,063,000	28,063,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,436,428	21,621,863

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	1,241,727	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,948,993	184,547,529
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,578,304	30,625,555
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,150,215,912.53</b>	<b>17,501,901,010.14</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,250,614,963	16,793,800,618
210502	Хоол, хүнс	780,561,000	627,347,892
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	119,039,950	80,752,500
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,269,087,953.00</b>	<b>1,151,976,564.84</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	708,078,000	491,868,286
210602	Тавилга		44,915,540.00
210604	Урсгал засвар	561,009,953	615,192,739
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>73,157,800.00</b>	<b>3,527,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	65,940,600	
210702	Дотоод албан томилолт	7,217,200	3,527,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>269,167,277.33</b>	<b>328,448,020.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	228,899,045	286,363,370
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,900,000	9,900,000
210803	Даатгалын үйлчилгээ	2,122,612	1,453,640
210804	Тээврийн хэрэгслийн татвар	463,328	655,560
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		50,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,200,000
210807	Газрын төлбөр	5,372,592	5,385,450
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,409,700	22,440,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,974,617,141.86</b>	<b>8,548,708,781.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,875,998,341.86	8,548,708,781.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	98,618,800	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>929,835,688.53</b>	<b>470,255,908.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>758,976,038</b>	<b>405,934,834</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	141,883,574	10,689,134
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	430,564,162	395,245,700
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	186,528,302	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>170,859,650.53</b>	<b>64,321,074.33</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	170,859,650.53	64,321,074.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,968,561,458.00</b>	<b>2,643,485,526.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,988,371,738.00</b>	<b>2,677,775,646.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,988,371,738.00</b>	<b>2,677,775,646.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,988,371,738.00</b>	<b>2,677,775,646.00</b>
223001	Бусад хөрөнгө	1,988,371,738.00	2,677,775,646.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,988,371,738.00)</b>	<b>(2,677,775,646.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(19,810,280.00)</b>	<b>(34,290,120.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>54,100,400.00</b>	<b>34,290,120.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>34,290,120.00</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,376,629,291.33	9,407,748,433.14	13,438,933,990.62		44,223,311,715.09
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,376,629,291.33	9,407,748,433.14	13,438,933,990.62	0.00	44,223,311,715.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		6,845,500.00			6,845,500.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			392,896,235.88		392,896,235.88
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	13,831,830,226.50	0.00	44,623,053,450.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	13,831,830,226.50	0.00	44,623,053,450.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			4,621,452,541.54		4,621,452,541.54
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	18,453,282,768.04	0.00	49,244,505,992.51

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>46,337,841,400.00</b>	<b>46,297,514,122.05</b>	<b>(40,327,277.95)</b>	<b>99.91%</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>46,337,841,400.00</b>	<b>46,297,514,122.05</b>	<b>(40,327,277.95)</b>	<b>99.91%</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,915,256,400.00</b>	<b>45,831,324,213.72</b>	<b>(83,932,186.28)</b>	<b>99.82%</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>12,695,290,300.00</b>	<b>12,695,290,300.00</b>	-	<b>100.00%</b>
210101	Үндсэн цалин	7,410,082,100.00	7,410,082,100.00	-	100.00%
210102	Нэмэгдэл	3,811,188,200.00	3,811,188,200.00	-	100.00%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	866,250,000.00	866,250,000.00	-	100.00%
210104	Урамшуулал	607,770,000.00	607,770,000.00	-	100.00%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,669,205,500.00</b>	<b>1,669,205,400.00</b>	<b>(100.00)</b>	<b>100.00%</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,242,689,300.00	1,242,689,200.00	(100.00)	100.00%
210202	Тэтгэмжийн даатгал	106,629,100.00	106,629,100.00	-	100.00%
210203	ҮОМШӨ-ний даатгал	85,303,200.00	85,303,200.00	-	100.00%
210204	Ажилгүйдлийн даатгал	21,325,800.00	21,325,800.00	-	100.00%
210205	Эрүүл мэндийн даатгал	213,258,100.00	213,258,100.00	-	100.00%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>937,786,800.00</b>	<b>937,786,800.00</b>	-	<b>100.00%</b>
210301	Гэрэл, цахилгаан	478,303,100.00	536,986,633.14	58,683,533.14	112.27%
210302	Түлш, халаалт	243,004,100.00	185,717,204.02	(57,286,895.98)	76.43%
210303	Цэвэр, бохир ус	216,479,600.00	215,082,962.84	(1,396,637.16)	99.35%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>316,841,300.00</b>	<b>316,704,491.96</b>	<b>(136,808.04)</b>	<b>99.96%</b>
210401	Бичиг хэрэг	50,943,100.00	51,846,545.00	903,445.00	101.77%
210402	Тээвэр, шатахуун	26,063,000.00	28,063,000.00	2,000,000.00	107.67%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,858,800.00	21,621,862.96	(2,236,937.04)	90.62%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,949,000.00	184,547,529.00	28,598,529.00	118.34%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,027,400.00	30,625,555.00	(29,401,845.00)	51.02%
2105	<b>Нормативт зардал</b>	<b>17,510,775,500.00</b>	<b>17,501,901,010.14</b>	<b>(8,874,489.86)</b>	<b>99.95%</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,794,037,600.00	16,793,800,618.02	(236,981.98)	100.00%
210502	Хоол, хүнс	630,561,600.00	627,347,892.12	(3,213,707.88)	99.49%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	86,176,300.00	80,752,500.00	(5,423,800.00)	93.71%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,943,332,000.00</b>	<b>3,792,752,210.84</b>	<b>(150,579,789.16)</b>	<b>96.18%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,318,016,600.00	2,161,462,828.00	(156,553,772.00)	93.25%
210602	Тавилга	86,400,000.00	137,150,930.00	50,750,930.00	158.74%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-	
210604	Урсгал засвар	1,538,915,400.00	1,494,138,452.84	(44,776,947.16)	97.09%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,702,000.00</b>	<b>5,527,200.00</b>	<b>(174,800.00)</b>	<b>96.93%</b>
210702	Дотоод албан томилолт	5,702,000.00	5,527,200.00	(174,800.00)	96.93%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>277,138,700.00</b>	<b>328,448,020.00</b>	<b>51,309,320.00</b>	<b>118.51%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,171,800.00	286,363,370.00	62,191,570.00	127.74%

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,900,000.00	9,900,000.00	-	100.00%
210803	Даатгалын үйлчилгээ	2,123,500.00	1,453,640.00	(669,860.00)	68.45%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	516,500.00	655,560.00	139,060.00	126.92%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогчоо	143,000.00	50,000.00	(93,000.00)	34.97%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.00	2,200,000.00	(5,300,000.00)	29.33%
210807	Газрын төлбөр	5,372,600.00	5,385,450.00	12,850.00	100.24%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,411,300.00	22,440,000.00	(4,971,300.00)	81.86%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,559,184,300.00</b>	<b>8,583,708,780.78</b>	<b>24,524,480.78</b>	<b>100.29%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,559,184,300.00	8,583,708,780.78	24,524,480.78	100.29%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>422,585,000.00</b>	<b>466,189,908.33</b>	<b>43,604,908.33</b>	<b>110.32%</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>60,255,074.33</b>	<b>60,255,074.33</b>	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		60,255,074.33	60,255,074.33	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>422,585,000.00</b>	<b>405,934,834.00</b>	<b>(16,650,166.00)</b>	<b>96.06%</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	400,085,000.00	395,245,700.00	(4,839,300.00)	98.79%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,500,000.00	10,689,134.00	(11,810,866.00)	47.51%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>46,337,841,400.00</b>	<b>46,263,224,002.05</b>	<b>(74,617,397.95)</b>	<b>99.84%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>14,507,014,200.00</b>	<b>14,507,014,200.00</b>	-	<b>100.00%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	14,507,014,200.00	14,507,014,200.00	-	100.00%
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>23,992,951,200.00</b>	<b>23,992,951,200.00</b>	-	<b>100.00%</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,992,951,200.00	23,992,951,200.00	-	100.00%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,837,876,000.00</b>	<b>7,734,758,602.05</b>	<b>(103,117,397.95)</b>	<b>98.68%</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,202,034,200.00	5,904,779,273.91	(297,254,926.09)	95.21%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,635,841,800.00	1,829,979,328.14	<b>194,137,528.14</b>	111.87%
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	28,500,000.00		
122001	Хандив тусламж /дотоод/		28,500,000.00		
122002	Хандив тусламж /гадаад/				
<b>14</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-		
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх				
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>34,290,120.00</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-		



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ерөнхий захирал Н.Лхажий танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Дабль аксиом Аудит” ХХК-ийн чанарын менежер Ч.Оюунцэцэг хянаж, аудитор Д.Отгонжаргал, аудиторын туслах Б.Бат-Оргил, аудиторын туслах С.Одгэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 1/77 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үйлчилгээний соёл, анагаах ухааны шинэ технологи, инновацыг эрхэмлэгч, шилдэг багийн тогтолцоотой олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох зорилт дэвшүүлэн ажилладаг байна.

##### **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО:**

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь эмчилгээ, сувилгаа, үйлчилгээ, орчны шинэчлэлийг олон улсын түвшинд нийцүүлэн сайжруулж, инновац, эрдэм шинжилгээ, судалгааны хамрах хүрээг өргөжүүлэн, эмнэлгийн мэргэшсэн, нэгдмэл, цогц тусламж, үйлчилгээг салбарын анхдагч, үндэсний манлайлагчаас дэлхийн жишигт хүргэхэд оршино.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын хэмжээнд эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Анагаах ухааны сургалт, судалгаа явуулах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх
- Эмнэлгийн байгууллагад мэргэжил, арга зүйн гурав дахь шатны лавлагаа тусламж үзүүлэх.

ЭМЯ-ны сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/53 тоот тушаалаар Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг Өмчлөгчийг төлөөлөх 3, Хамт олныг төлөөлөх 3, Олон нийтийг төлөөлөх 3 нийт 9 гишүүнтэйгээр батламжилсан байна.

ЭМЯ-ны сайдаас 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 1а/565 тоот албан бичгээр Төлөөлөн удирдах зөвлөл болон эмнэлгийн гүйцэтгэх удирдлага нь бие даасан үйл

ажиллагаа явуулахдаа Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” техник туслалцааны төслийн дэмжлэгийг авч хамтран ажиллахыг чиглэл болгосон байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2020 онд Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5”(ЭМСХХ-5) Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Улсын Нэгдүгээр төв эмнэлэг “Хоёр талт буюу амбулаторийн эмийн сан”-г Монголд анх удаа ашиглалтад оруулсан байна. ЭМДЕГ-аас уг дундаж үнийн 70 хүртэл хувийг ЭМД-аас төлөхөөр журам гаргасны дагуу иргэд ийнхүү хөнгөлөлттэй үнээр, цаг алдалгүй эмээ авах боломж бүрдэж, үйлчлүүлэгчийн эмийн хэрэглээний цахим мэдээллийн дата үүсэж, эмчилгээний чанарыг сайжруулахад чухал алхам болсон байна. Тус эмийн сан дөрвөн цонхоор, нарийн мэргэжлийн найман эм зүйч ажиллаж байна.
- Дотрын нэгдсэн хэсэгтээ VIP тасаг байгуулан төлбөртэй үйлчилгээг нийт орлогын 6-10 хувиас хэтрүүлэхгүй байхаар зохицуулан ажилласан байна.
- Цахим системийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлж, улмаар 21 аймгийн хоёрдугаар шатлалын эмнэлгээс шууд цахимаар үзүүлэх цагаа захиалан үйлчлүүлдэг болсноор иргэд, үйлчлүүлэгчид хүлээгдэл, чирэгдэлгүй захиалсан цагтаа ирж үзүүлэх боломж бүрдсэн юм.
- Ухаалаг системийг эмчилгээ, үйлчилгээндээ нэвтрүүлэх зорилтын хүрээнд үйлчлүүлэгчийн хурууны хээг цахим бүртгэлд бүртгэх төвлөрсөн системийг нэвтрүүлснээр үйлчлүүлэгч хурууны хээгээ уншуулаад киоск машинаас шинжилгээнийхээ хариуг хугацаа алдалгүй, шуурхай, хялбар аргаар авах боломжтой болсон.
- Иргэдэд илүү хурдан шуурхай, найдвартай үйлчлэх үүднээс Амбулаторийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн зөв менежментээр нэвтрүүлснээр хүлээгдлийг 84 хувиар бууруулсан байна.
- Эрчимт эмчилгээний тасгийн хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, 9 ортой байсан тасгийг 18 ортой болгон, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн ханган, стандартад нийцсэн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлжээ.
- Өнгөрсөн нэг жилийн хугацаанд иргэдэд эмнэлгийн хамгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх “Яаралтай тусламжийн тасаг”-ийн ажиллах хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, үйлчлүүлэгчид шаардлагатай оношилгоо, шинжилгээг газар дээр цогцоор, яаралтай хийдэг болсон байна.
- Эрүүл мэндийн салбартаа төрөлжсөн сургалтын төвийг төрөлжсөн номын сан болон гардан үйлдлийн сургалтын хэсгийг багтаан байгуулсан тус эмнэлгийн хувьд сургалтын жишиг эмнэлэг учраас тус шинээр байгуулагдсан сургалтын төв дээр бүх талын эмч, мэргэжилтнүүдийг сургаж, бэлтгэх боломж бүрджээ.
- “Зүрхний шигдээсний нэгж”-ийг 10 ортойгоор өөрийн эмнэлэг дээрээ байгуулан, зүрхний титэм судсанд дотуурх эмчилгээний тусламж үйлчилгээг (7/24 цагийн) зарчмаар тасралтгүй явуулж, нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болох зүрхний шигдээсний өвчнийг эмчлэх, цогц арга хэмжээ авах төв болсон байна.
- Тус эмнэлэг нь улсын хэмжээнд дурангийн оношилгоо, эмчилгээг хийдэг гол төв учир дурангийн оношилгоо, эмчилгээг цогцоор нь олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн, халдвар, хамгааллын дэглэмийн дагуу өргөжүүлэн бүрэн засварлаж иж бүрэн шинэчлэлтийг хийсэн байна.



- Дотор болон мэс заслын эмнэлзүйн зөвлөл байгуулж, дотрын нэгдсэн төвийг байгуулсан. Энэхүү зохион байгуулалт, төлөвлөлтөөрөө дамжуулан нийт 140 орны хэвтэлт гаралтын нэгдсэн системийг бий болгож, хэвтэн эмчлүүлэгчийн орны хүлээгдлийг гурав дахин бууруулсан байна.
- Цар тахлын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварыг бууруулах зорилгоор 12 ортой тусгаарлах хэсгийг байгуулан ажилласан нь сэжигтэй тохиолдлыг цаг алдалгүй тусгаарлах бүрэн боломжтой болсон байна.
- Олон улсын стандартад нийцсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношилгооны иж бүрэн төв болох “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг ашиглалтад оруулсан байна.
- Эмч, эмнэлгийн ажилтныхаа хандлагыг өөрчилж, иргэдэд ойр, дотно үйлчилгээг бүрдүүлэх зорилгоор “Хандлагын 10 хувь” урамшууллын системийг эмнэлгийн нийт 810 ажилтанд хэрэгжүүлж, үйлчлүүлэгчээс тухайн ажилтны нэр дээр гомдол санал ирэхгүй бол хандлагын урамшуулал авч, эсрэгээр гомдол, шүүмжлэл баримт, нотолгоотой ирвэл урамшууллыг олгохгүй ажилласан байна.
- Нийт үйлчлүүлэгчдэд болон эмч эмнэлгийн ажилчдад ээлтэй орчин бүрдүүлж, хурлын заал, лаборатори, амбулатори, эргэлтийн хэсэг, эмнэлгийн гадна талбай зэрэг 4000 м2 талбайг засварлан шинэчилжээ.
- Тайлант жилийн хугацаанд нэвтрүүлсэн эмчилгээний шинэ технологиуд нь
  - Тархины үхэлтэй донороос яс болон шөрмөсийг шилжүүлэн суулгах
  - Өвдөг үений мөрний дурангийн мэс засал
  - Бамбай булчирхай дурангаар авах
  - Хамрын таслагчийн цоорхой нөхөн сэргээх
  - Хамрын хөндийн доод самалдаг шилжүүлэн суулгах
  - Тархины хавдар авах мэс засал
  - Үрийн суваг залгах мэс засал

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шинэ коронавирсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай МУ-ын ЗГ-ын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 тоот тогтоол
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай МУ-ын ЗГ-ын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 114 тоот тогтоол

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байгаа боловч шинэчлэгдсэн стандарт, хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Эрүүл мэндийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагын 42,229,483.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 422,294,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,221,264.5 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/Мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,290.2	0.00	-34,290.2
Авлага	95,939.9	67,326.9	-28,613.0
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	5,193,331.9	5,733,498.1	540,166.2
Үндсэн хөрөнгө	39,352,898.3	44,096,899.8	4,744,001.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>44,676,460.3</b>	<b>49,897,724.8</b>	<b>5,221,264.5</b>
Өр төлбөр	53,406.8	653,218.8	599,812.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	44,623,053.5	49,244,506.0	4,621,452.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>44,676,460.3</b>	<b>49,897,724.8</b>	<b>5,221,264.5</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй болж 34,290.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 67,326.9 мянган төгрөг болж 28,613.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн авлага буурч, тайлант онд зарцуулагдаагүй үлдсэн 60,255.1 мянган төгрөгийг Сангийн яаманд татан төвлөрүүлж авлагаар бүртгэсэн нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019, 2020 онуудад үүссэн 4,071.0 мянган төгрөгийн авлага байгаагаас байгууллагаас авах 3,666.0 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 405.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,733,498.1 мянган төгрөг болж 540,166.2 мянган төгрөгөөр өссөн нь урсгал санхүүжилтээр 45,105,450.13 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүй, хандив тусламжаар 344,200.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, түлш, жижиг багаж хэрэгсэл хүлээн авсан нь шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд насжилт өндөр, ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст 26,236,369.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас онцгой нөхцөл байдал үүссэн, эмнэлэг хагас бие даасан зохион байгуулалтад орж шинэ төвүүдийг нээж хэвийн ажиллагаанд оруулсан нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансанд хөрөнгө оруулалтаар бэлтгэн харьяа байгууллагууд болон захиалагч байгууллагад шилжүүлээгүй бүртгэлтэй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,096,899.8 мянган төгрөг болж 4,744,001.5 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд урсгал төсвийн санхүүжилтээр 2,677,775.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, хандив тусламжаар 31 нэр төрлийн 109 ширхэг 7,421,451.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 6,986,601.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 2,677,775.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 434,849.5 мянган төгрөгөөр хөрөнгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 295 тоот тогтоолоор акталсан 671,769.1 мянган төгрөгийн хөрөнгөөр, ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А-1/791 тоот албан тоот албан бичгийн дагуу номын фондыг үндсэн хөрөнгөөс хасаж бараа материалд 58,663.4 мянган төгрөгөөр шилжүүлэн бүртгэж нийт 730,432.5 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд биет бус хөрөнгөнд 30,000.0 мянган төгрөгөөр Интерактив компаниас VERITECH санхүүгийн программ, 5,000.0 мянган төгрөгөөр Альфа софт ХХК-иас Хэвтэлт гаралтын программд модульд хөгжүүлэлт хийгдэж нийт 35,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 653,218.8 мянган төгрөг болж 599,812.0 мянган төгрөгөөр өссөн нь:

- Засгийн газрын байгууллага, бусад шатны төсвийн төгрөгөөрх зээлийн өглөг буюу 2032 он хүртэл хуваарьтай өглөг 35,348.1 мянган төгрөг.
- ТӨБЗГ-ын 2019 оны журмын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс түрээсийн талбайн барьцаа баталгаа байршуулсан 37,518.0 мянган төгрөг
- 2020 оны 12 дугаар сарын 22-25-ны өдрүүдийн гүйлгээнд хийгдсэн боловч программын таталт хийгээгүйгээс орхигдсон түрээсийн төлбөрийн үлдэгдэл 34,165.6 мянган төгрөг
- Цар тахлын үеийн ковидын нөөц бүрдүүлсэн 211,588,0 мянган төгрөг

- Шинээр нээгдсэн эмийн сангийн үйл ажиллагаа жигдрээгүй мөн орлого биелэх хугацаанаас хамаарч 102,493.2 мянган төгрөг
- Шинээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэнтэй холбогдон эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисын 228,041,5 мянган төгрөгийн өглөг үүссэн зэрэг нь шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2020 оны 37,518.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, нийт өр төлбөрийн 5.7 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,184.0 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны өөрийн орлого 4,3 дахин, туслах үйл ажиллагааны орлого 5.6 дахин нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 6,968,739.9 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэгдэл цалин 59.0 хувиар, ном хэвлэлийн зардал 4 дахин, дотоод албан томилолт 42.0 хувиар, даатгалын үйлчилгээ 3 дахин, бараа ажил үйлчилгээний бусад зардал 2 дахин өссөн байна. Энэ нь эмнэлэг хагас бие даасан тогтолцоонд шилжин шинээр тасаг төвийн зохион байгуулалтад орсноор тусламж үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэнтэй холбогдон зардал нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 41,775,278.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан боловч ТУЗ-ийн тогтоолоор 2020 оны төсөвт 5 удаа нэмэлт тодотгол, 4 удаа төсвийн зохицуулалт хийгдсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,562,563.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 46,337,841.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж шинэ дэвшилт технологи нэвтрүүлэн үйл ажиллагаагаа өргөтгөж байгаатай холбогдон цалин хөлсний зардалд 1,332,381.6 мянган төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 1,379,901.7 мянган төгрөг, багаж, техник, хэрэгслийн зардалд 1,401,816.6 мянган төгрөгийн материаллаг өөрчлөлт гарсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 46,337,841.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 14,507,014.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,992,951.2 мянган төгрөгийг ЭМД-ийн санхүүжилтээс, 6,202,034.2 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,635,841.8 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 14,507,014.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,992,951.2 мянган төгрөгийг ЭМД-ийн санхүүжилтээс, 5,904,779.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,829,979.3 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлж, зарцуулагдаагүй үлдсэн 60,255.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 46,297,514.1 мянган төгрөг буюу 99.91 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардлыг 65,809.8 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 25,964.9 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4,066.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийг хуваарилсан боловч төрийн өмчит төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг болон эмнэлгийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж, хагас бие даасан тогтолцоонд шилжсэнтэй холбогдож нэмэлт санхүүжилтийн данс хаагдсан тул улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 162 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 6 мэдээлэл, хугацаа нь болоогүй 5 мэдээлэл байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 58,515.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 313,175.5 мянган төгрөгийн 8 зөвлөмжийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	2	58,515.3	2	58,515.3			100
Зөвлөмж	8	313,175.5	7	313,175.5	1		87.5
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>371,690.8</b>	<b>9</b>	<b>371,690.8</b>			

2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 тогтоолоор бүтэц орон тоо өөрчлөгдөж, ТУЗ-д хараат бус дотоод аудитор ажиллуулахтай холбоотойгоор гэрээгээр ажиллаж байсан дотоод аудиторыг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гэрээг цуцалсан нь дотоод аудиторын ажил үүргээр хангах нөхцөл бүрдээгүйгээс өмнөх аудиторын зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна

### **3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 817,720.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 106,737.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 524.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 209,552.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 500,905.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнэ хөлсөнд 69,219.3 мянган төгрөгийг шилжүүлснийг бүртгэхдээ тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэснийг залруулав.
2. ТӨБЗГ-аас батлагдсан журмын дагуу шилжиж ирсэн түрээсийн хөрөнгийн барьцаа 37,518.0 мянган төлбөрийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд орлого авч, тухайн түрээслэгч байгууллагуудад өглөг үүсгэхдээ зардлын данс руу хаалт хийснийг залруулав.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 710,983.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 524.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 209,552.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Захирлын 2020 оны №Б/681 тоот тушаалын дагуу 2020 оны 8 дугаар сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтанд ажилласан хугацааны цалингийн нөхөн олговрыг 524.6 мянган төгрөгийг илүү бодож, олгосон.

#### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант онд хангамж, засварын материал худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулалгүй, харьцуулалтын үнийн арга хэрэглэн “Баянсоёмбо” ХХК-тай 23,980.0 мянган, “ТиТиЖи” ХХК-тай 30,368.2 мянган, “Голден Хоум” ХХК-тай 48,676.8 мянган, “Тэнгэрийн бэрээ” ХХК-тай 18,700.0 мянган, “Эх цайз цонх” ХХК-тай 22,495.0 мянган төгрөгийн, компьютер, дагалдах хэрэгслийг бэлтгэх тендерийн нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн байгууллагатай 65,322.7 мянган төгрөгийн, нийт 209,552.7 мянган төгрөгийн гэрээг шууд байгуулсан байна.

#### Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх



#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 500,905.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт нь он дамжин хийгддэг, өндөр өртөгтэй, худалдан авалтын ажлыг зохион байгуулахдаа цахим системд байршуулж, нийтэд зарлан мэдээлэлгүй шууд харьцуулалтын үнийн аргаар авдаг тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл технологийн хэлтэс нь 2021 онд Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, Гемодиализын үйлчилгээг үзүүлж буй Эрүүл мэндийн байгууллагуудад хуруу уншигч төхөөрөмж суурилуулж даатгуулагчийн авч буй үйлчилгээний тоо, төлбөрийн хэмжээг хянах боломжийг бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн яамнаас санхүүжигдэж буй дээрх төрлийн үйлчилгээний санхүүжилт мэдээлэл технологийн төвийн мэдээллийн сан дахь бүртгэлийн мэдээллийн дагуу байгаа эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1.1 *Илрүүлэлт:* Мөнгөн кассаас ахмадын өдрийн зардалд 8,440.0 сая төгрөгийг ЖМС-ийн хязгаарыг зөрчиж, тооцооны дансаар дамжуулалгүй зарцуулж, шууд зардалд бүртгэсэн нь Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.5 дахь “Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө”, тус журмын 6.3 дахь “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна” заалтууд, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
- 1.1.2 *Эрсдэл:* Мөнгөн хөрөнгөнд тавих дотоод хяналт сулрах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль журам зөрчигдөх
- 1.1.3 *Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 276 тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах
- 1.1.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.
- 1.2.1 *Илрүүлэлт:* Эмнэлгийн 95 жилийн ойн баярын хандивын 28,500.0 мянган төгрөгийг кассын орлогыг дансанд төвлөрүүлээгүй ба үүнээс ойн арга хэмжээнд 25,482.6 мянган төгрөгийг ЖМС-ийн хязгаарыг зөрчиж зарцуулж, шууд зардлаар тайлагнасан нь Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.5 дахь “Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө”, 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассадаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” заалтууд, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
- 1.2.2 *Эрсдэл:* Мөнгөн хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналт сулрах, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль журам зөрчигдөх



1.2.3 *Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, Сангийн сайдын 2012 оны 276 тушаалын 1 дүгээр хавсралтыг мөрдөж ажиллах

1.2.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **2.Балансын данстай холбоотой асуудал**

1.1 *Илрүүлэлт:* Нийт 432 байгууллагад шилжүүлсэн төлбөрийг и баримтад шивэгдсэн дүнтэй тулгалт хийхэд 220 байгууллага и баримтыг дутуу оруулж, 106 байгууллагын и баримт илүү оруулсан байгаа нь татварын цахим системд шивэгдэх НХМаягт ТМ-5 төлбөрийн баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.1 *Эрсдэл:* Худалдаж авч байгаа бараа, ажил, үйлчилгээ буюу байгууллагаас гарч байгаа зардалд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сулрах, ажил гүйлгээний дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй байх.

2.2 *Өгсөн зөвлөмж* Анхан шатны үнэн зөв баримтад /цахим И баримт/ үндэслэн төлбөр шилжүүлж байх.

2.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3. Балансын данстай холбоотой асуудал**

3.1 *Илрүүлэлт:* Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнэ хөлс 63,194.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэсэн байна. Энэ нь

3.2 *Эрсдэл:* Бүртгэлээр тавих хяналт суларч, үр дүн буруу илэрхийлэгдэж, санхүүгийн мэдээлэл хэрэглэгч буруу дүгнэлтэд хүрэх.

3.3 *Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллах.

3.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **4.Балансын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлант онд эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй ба төсөвт өртгийг хувааж нийт 403,788.7 мянган төгрөгийн гэрээг шууд байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1 дэх "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно, 21.1 дэх "Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэсэн заалтууд, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.1 *Эрсдэл:* Худалдаж авах ажиллагаанд тавих дотоод хяналт сул, хууль тогтоомж хэрэгжихгүй байх.

4.2 *Өгсөн зөвлөмж* Хууль тогтоомжид заасны дагуу тендерийг цахимаар зохион байгуулах, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг журмын дагуу боловсруулан батлуулж, ижил шинж чанарын ижил төрлийн бараа материалын тендерийг нийт өртгөөр тооцон зарлаж байх,

4.3 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **5.Балансын данстай холбоотой асуудал**

5.1 *Илрүүлэлт:* Програмаас эхсэл файл руу тайлан, журнал хөрвүүлэхэд гүйлгээ давхардах, дебет кредит дансны бичилт хоорондоо солигдох, зөрүүтэй татагдах, хэт их ачааллаж удах зэрэг нь хэрэглэгчдийг мэдээллээр буруу хангах эрсдэлтэй байна.

5.2 *Эрсдэл:* Мэдээлэл хэрэглэгчдийг буруу, алдаатай мэдээллээр хангах, алдаатай мэдээллээс шалтгаалан шийдвэр буруу гарах

5.3 *Өгсөн зөвлөмж* Хууль, тогтоомжид заасан шаардлагын дагуу программд өргөтгөл шинэчлэлийг хийх.

5.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2021.02.25

Аудитын  
нэр:

*Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны  
жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудит*

Аудитын код:

САГ-2021/61/СТА-ТШЗ

Шалгагдсан  
байгууллагын нэр:

Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул- лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Программаас эхсэл файл руу тайлан, журнал хөрвүүлэхэд гүйлгээ давхардах, дебет кредит дансны бичилт хоорондоо солигдох, татагдахгүй, буруу мэдээллээр хангах		Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Б.Банзрагч
2	Мөнгөн касснаас ахмадын өдрийн зардалд 8,440.0 мянган төгрөгийг ЖМС-ийн хязгаарыг баримтлаагүй, тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн	8,440.0	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Б.Банзрагч
3	Нийт 432 байгууллагад шилжүүлсэн төлбөрийг и баримтад шивэгдсэн дүнтэй тулгалт хийхэд 220 байгууллага и баримтыг дутуу оруулж, 106 байгууллагын и баримт илүү оруулсан байгаа нь нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд нь бүрдэл дутуу баримтаар хөрөнгө бараа материалыг орлогод хүлээн авч бүртгэдэг		Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч, Хөрөнгө, бараа материалын нягтлан бодогч, Эмийн орлогын нягтлан бодогч	Б.Банзрагч, Ж.Хонгорзул, Б.Золзаяа
4	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнэ хөлс 63,194.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлын дансанд бүртгэсэн	63,194.6	Зөвлөмж	Ерөнхий нягтлан бодогч	Б.Банзрагч
5	Тайлант онд хангамж, засварын материал худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй, харьцуулалтын үнийн арга хэрэглэн 144,230.0 мянган төгрөг, ижил төрлийн, ижил шинж чанар бүхий материалыг тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор	209,552.7	Албан шаардлага	Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Захирлын ажлын албаны дарга, Эдийн засагч ЭХААХТА-ны албаны дарга	Б.Түвшинтөр Ц.Амаржаргал С.Батцэнгэл Г.Баяр

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	нийт төсөвт өртгийг хувааж 65,322.7 мянган төгрөг, нийт 209,552.7 төгрөгийн шууд гэрээ байгуулсан				
6	Тайлант онд эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй, 12 байгууллагаас 380,154.9 мянган төгрөг, тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж 3 байгууллагаас 23,633.8 мянган төгрөг, нийт 403,788.7 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан	403,788.7	Зөвлөмж	Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Захирлын ажлын албаны дарга, Эдийн засагч ЭХААХТА-ны албаны дарга	Б.Түвшинтөр Ц.Амаржаргал С.Батцэнгэл Г.Баяр
7	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны №Б/681 тоот захирлын тушаалын дагуу 8 дугаар сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтанд ажилласан хугацааны цалинг нөхөн олгохдоо 524,631.00 төгрөгийг илүү бодож, олгосон	524.6	Акт	Ерөнхий нягтлан бодогч, цалингийн нягтлан бодогч	Б.Банзрагч Н.Урансүрэн
8	Эмнэлгийн 95 жилийн ойн баярын хандивт 28,500.0 мянган төгрөгийг кассад бэлнээр хүлээн авч дансанд төвлөрүүлэлгүй, ойн арга хэмжээний зардалд 25,482.6 мянган төгрөгийг ЖМС-ийн хязгаарыг зөрчиж, тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан	25,482.6	Зөвлөмж	Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Орлогын нягтлан Ахлах касс	Б.Түвшинтөр Т.Одхүү О.Оюунтүлхүүр
<b>ДҮН</b>		<b>710,983.2</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 49/А0170064

Улаанбаатар хот

САГ-2021/61/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны №Б/681 тоот захирлын тушаалын дагуу 8 дугаар сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй ажилтанд ажилласан хугацааны цалинг нөхөн олгоходоо 524,631.00 (Таван зуун хорин дөрвөн мянга зургаан зуун гучин нэгэн) төгрөгийг илүү бодож, олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-т "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна", Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т "Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Gazar48.Docx

001090540

Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:


1. Ажилтанд илүү тооцож олгосон 524,631.00 (Таван зуун хорин дөрвөн мянга зургаан зуун гучин нэгэн) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирал Н.Лхажий, Санхүү, бүртгэлийн албаны дарга Б.Банзрагч нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

П.АМАРСАНАА

Т.МЯГМАРСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 176/А070064

Улаанбаатар хот

С.АТ. 2021/61/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хангамж, засварын материал худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулалгүй, харьцуулалтын үнийн арга хэрэглэн 144,230.0 мянган төгрөгийн, ижил төрлийн, ижил шинж чанар бүхий материалын тендерийг төсөвт өртгийг хувааж 65,322.7 мянган төгрөгийн, нийт 209,552.7 мянган төгрөгийн гэрээг шууд байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийн үндэслэл болгоно", Засгийн газрын 377 дугаар тогтоолын 1.7(в)-д "Худалдан авах ажиллагааг цахимаар / tender.gov.mn/ зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжид заасны дагуу тендерийг зохион байгуулах, ижил шинж чанарын ижил төрлийн бараа материалын тендерийг нийт төсөвт өртгөөр төлөвлөж, зохион байгуулах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирал Н.Лхажий, ерөнхий нягтлан бодогч Б.Банзрагч нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.АМАРСАНАА  
Т.МЯГМАРСҮРЭН

